

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2026 оны 1-р сарын 01 - 2026 оны 6-р сарын 30
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	СҮҮ ХК УБГД: 000219594 УЦК: 135-СҮҮ Утас: 7707-2222
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Сүүний тээврийн үйлчилгээ Үхрийн сүүний фермерийн аж ахуй Хүнсний ногоо тариалах Малын тэжээлийн ургамал тариалах Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	344.000.000 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ерөнхий нягтлан бодогч Д.Дэлгэрэхжаргал
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт Тайлан хавсаргав.
	Орлогын тайлан Тайлан хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан Тайлан хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан Тайлан хавсаргав.
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
	Хурлаар хэлэлцэж баталгаажуулсан.
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ Нийт ашгийн хувь – 32.13% Цэвэр ашгийн хувь – 8.99% Нийт хөрөнгийн өгөөж (ROA)- 3.02% Өөрийн хөрөнгийн өгөөж(ROE)- 8.02%
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт Эргэлтийн харьцаа – 0.97 Түргэн хөрвөх чадварын харьцаа – 0.54
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, сүүлийн үеийн шинэ техник, технологийг нэвтрүүлж хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн,

	компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	чанартай бүтээгдэхүүнүүдийг гарган гадаад, дотоод орчны нөлөөллийг бууруулан ажиллаж байна. Хамгийн сүүлийн байдлаар лактозгүй сүүг шинээр үйлдвэрлэн худалдаанд гаргасан нь олон мянган хэрэглэгчийн талархлыг хүлээсэн бүтээгдэхүүн болсон байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НБББББичгийн дагуу бүртгэсэн.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний этгээдийн талаарх мэдээллийг тусгана/
	1. "Сүү" ХК-ийн 2026 оны 01 сарын 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №02 тогтоолын дагуу худалдах худалдан авах гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, барьцааны гэрээ, зээлийн гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, тээвэрлэлтийн гэрээнүүдийг 2026 оны 01 сарын 16-ны өдрөөс 2026 оны 01 сарын 16-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд холбогдох дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээний хүрээнд "Макс Импекс" ХХК-тай 3,000,000,000 ₮ хүртэлх үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг зөвшөөрсөн. 2. "Сүү" ХК-ийн 2026 оны 01 сарын 20-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн №2-1 тогтоолын дагуу Монголын Теннисний Холбоо НҮТББ-тай 100,000,000 төгрөг хүртэл үнийн дүн бүхий санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ, ивээн тэтгэлгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнүүдийг 2026 оны 01 сарын 20-ны өдрөөс 2027 оны 01 сарын 20-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд тухай бүр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн. 3. "Сүү" ХК-ийн 2026 оны 06 сарын 26-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №15 тогтоолын дагуу "Сүү Трейд" ХХК-ийн 100 хувийн хувьцааг бүхэлд нь үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авахыг зөвшөөрсөн.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжисж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгосон хувьцаа гаргаагүй.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Төлөөлөн удирдах зөвлөлтэй ба 12 гишүүнтэй, "Нэр дэвшүүлэх", "Цалин урамшуулал", "Аудитын", "Эрсдэлийн удирдлага, комплайнс" гэх 4 хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна.	
6.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	
	Компанийн засаглалын кодекстэй холбоотойгоор шат дараатай ажлуудыг хийж байгаа.	

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Гантулга "СҮҮ" ХК-ийн гүйцэтгэх захирал
Албан тушаал: "СҮҮ" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Дэлгэрэхжаргал
Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2026 оны 1-р сарын 01 - 2026 оны 6-р сарын 30
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	СҮҮ ХК УБГД: 000219594 ҮЦК: 135-СҮҮ Утас: 7707-2222
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Сүүний тээврийн үйлчилгээ Үхрийн сүүний фермерийн аж ахуй Хүнсний ногоо тариалах Малын тэжээлийн ургамал тариалах Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	344.000.000 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ерөнхий нягтлан бодогч Д.Дэлгэрэхжаргал
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	Орлогын тайлан
	Өмчийн өөрчлөлтийн тайлан
	Мөнгөн гүйлгээний тайлан
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
	Хурлаар хэлэлцэж баталгаажуулсан.
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/
	Нийт ашгийн хувь – 32.13% Цэвэр ашгийн хувь – 8.99% Нийт хөрөнгийн өгөөж (ROA)- 3.02% Өөрийн хөрөнгийн өгөөж(ROE)- 8.02%
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт
	Эргэлтийн харьцаа – 0.97 Түргэн хөрвөх чадварын харьцаа – 0.54
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд
	Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, сүүлийн үеийн шинэ техник, технологийг нэвтрүүлж хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн,

	компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	чанартай бүтээгдэхүүнүүдийг гарган гадаад, дотоод орчны нөлөөллийг бууруулан ажиллаж байна. Хамгийн сүүлийн байдлаар лактозгүй сүүг шинээр үйлдвэрлэн худалдаанд гаргасан нь олон мянган хэрэглэгчийн талархлыг хүлээсэн бүтээгдэхүүн болсон байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НБББББичгийн дагуу бүртгэсэн.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	1. "Сүү" ХК-ийн 2026 оны 01 сарын 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №02 тогтоолын дагуу худалдах худалдан авах гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, барьцааны гэрээ, зээлийн гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, тээвэрлэлтийн гэрээнүүдийг 2026 оны 01 сарын 16-ны өдрөөс 2026 оны 01 сарын 16-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд холбогдох дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээний хүрээнд "Макс Импекс" ХХК-тай 3,000,000,000 ₮ хүртэлх үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг зөвшөөрсөн. 2. "Сүү" ХК-ийн 2026 оны 01 сарын 20-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн №2-1 тогтоолын дагуу Монголын Теннисний Холбоо НҮТББ-тай 100,000,000 төгрөг хүртэл үнийн дүн бүхий санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ, ивээн тэтгэлгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнүүдийг 2026 оны 01 сарын 20-ны өдрөөс 2027 оны 01 сарын 20-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд тухай бүр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн. 3. "Сүү" ХК-ийн 2026 оны 06 сарын 26-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №15 тогтоолын дагуу "Сүү Трейд" ХХК-ийн 100 хувийн хувьцааг бүхэлд нь үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авахыг зөвшөөрсөн.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгосон хувьцаа гаргаагүй.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Төлөөлөн удирдах зөвлөлтэй ба 12 гишүүнтэй, "Нэр дэвшүүлэх", "Цалин урамшуулал", "Аудитын", "Эрсдэлийн удирдлага, комплайнс" гэх 4 хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна.	
6.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	
	Компанийн засаглалын кодекстэй холбоотойгоор шат дараатай ажлуудыг хийж байгаа.	

МХБ Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн
47 дугаар тогтоолын хавсралт
“Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх
мэдээллийн журам”

7.	Үнэт цаас гаргагчийн бүтэц (толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд, тэдгээрийн хувь эзэмшлийн талаар), холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл;
	Ийм мэдээлэл байхгүй.
8.	Үнэт цаас гаргагч нь (Банк, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, болон Үнэт цаасны компани) төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
	-
9.	Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах, компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэх, компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болох нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл
	Ийм нөхцөл байдал үүсээгүй.
10.	Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулал олгосон талаарх мэдээлэл
	Байхгүй.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэт зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Гантулга
Албан тушаал: “СҮҮ” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Дэлгэрэхжаргал
Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:
b.d.



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

2026

ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН



01

ТАНИЛЦУУЛГА

- Товч танилцуулга
- Алсын хараа, Үнэт зүйл, Эрхэм зорилго
- Түүхэн замнал
- Хувьцаа эзэмшигч
- ТУЗ-ийн танилцуулга
- ТУЗ-ийн дэргэдэх хороод
- Удирдлагын багийн танилцуулга
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний салбарын анхдагч Сүү ХК нь 1958 оноос хойш үндэсний хүн амыг чанартай, аюулгүй хүнсээр хангах эрхэм зорилгоо тууштай хэрэгжүүлсээр ирсэн билээ. Бид уламжлал, түршлагаа инновацтай хослуулан үндэсний брэндийн үнэ цэнийг үе үеийн хэрэглэгчдэд хүргэж байна.

Сүү ХК нь 800 гаруй ажилтан, албан хаагчтай, хоногт 200 тонн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадал бүхий орчин үеийн үйлдвэрийг амжилттай ажиллуулж, 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг 7,000 борлуулалтын цэгээр дамжуулан хэрэглэгчдэд түгээж буй.

Бид түүхий эдийн тогтвортой хангамжийг хангах, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих зорилгоор малчид, фермерүүдийг нэгтгэсэн сүү бэлтгэлийн хоршооны тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлж байна. Одоогоор 34 сүү бэлтгэлийн хоршоо тогтвортой үйл ажиллагаа явуулж, бүс нутгийн эдийн засагт бодитой хувь нэмэр оруулсаар байгаа билээ.

Мөн Улаанбаатар хотыг төв болгон 350 км-ийн радиуст орших Төв, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хэнтий, Булган зэрэг 6 аймгийн 2,500 гаруй сүү бэлтгэн нийлүүлэгч, малчид, фермерүүдтэй хамтран ажиллаж, жилийн дөрвөн улирал тасралтгүй түүхий эд татан авдаг нэгдсэн логистик, ханган нийлүүлэлтийн системийг бүрдүүлээд байна.

Сүү ХК нь хүнсний аюулгүй байдал, чанар, инновац, тогтвортой хөгжлийг эрхэмлэн Монголын сүүний салбарын шинэ үеийг манлайлан хэрэглэгчдэд эрүүл, баталгаатай бүтээгдэхүүнийг хүргэхийг зорин ажиллаж байна.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР

Сүү Хувицагт Компани

АЛСЫН ХАРАА

Монгол сүүгээр
дэлхийг ундаална

ЭРХЭМ ЗОРИЛГО

Уламжлан ирсэн сүүн соёлыг
орчин үеийн хэрэгцээнд
нийцүүлэн түгээнэ

ҮНЭТ ЗҮЙЛС

67 жилийн ТҮРШЛАГА, ЭРҮҮЛ хүн,
АЮУЛГҮЙ ажиллагаа, ИТГЭЛ
даасан ЧАНАР, ЧАДВАРЛАГ хамт
олон

УРИА ҮГ

Сүүн соёлыг түгээнэ

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ТҮҮХЭН ЗАМНАЛ

1958-1985

БАЙГУУЛАГДСАН ҮЕ

- 1958 онд хоногт 30 тн боловсруулах үйлдвэр ашиглалтад оров.
- 1985 онд барилга, тонох төхөөрөмжийн шинэчлэл хийж, одоогийн СХД-т үйл ажиллагаагаа эхлүүлэв.
- Гурвалжин сүү, шилтэй тараг, аарц, ааруул, зайрмаг зэрэг үндэсний бүтээгдэхүүнийг гаргав.

2007-2023

СТАНДАРТ, ЧАНАР

- ISO 9001, OHSAS 18001, ISO 45001 НАССР тогтолцоо бүрэн нэвтрүүлэв.
- Чанар, аюулгүй байдлын олон улсын баталгааг хэрэгжүүлэв.

1941-1957

ҮҮСЭЛ

- Сүү хүлээн авах 300 тасаг, цөцгийн тосны 2 үйлдвэр байгуулагдав.
- 1946 онд 300 тн цөцгийн тосыг экспортлов.
- Сүү ХК-ийн үндэс суурь тавигдав.

1986-2006

ЗАХ ЗЭЭЛИЙН ШИЛЖИЛТ, ШИНЭЧЛЭЛ

- 1991 онд хувьчлалаар төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болов.
- Үйлдвэрлэлийн хэмжээ 34 дахин буурсан хүнд үеийг туулав.
- 2006 онд бүрэн хувьчлагдаж, шинэчлэл, хөрөнгө оруулалтын үе эхлэв.
- Орчин үеийн пьюрпак савлагааны шугам нэвтрүүлэв.

2023-2026

ШИНЭ ҮЕ – СҮҮ 2.0

- 44 тэрбум ₮ хөрөнгө оруулалт.
- Үйлдвэрлэлийн хүчин чадал 2 дахин өсөв.
- СҮҮ 2.0 төсөл эхэлж, экспортын суурь тавигдав.
- "Монгол сүүгээр дэлхийг ундаалах" шинэ шат эхлэв.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ




МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Нөлөө бүхий хувьцаа ЭЗЭМШИГЧИД:

38.69%	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч
33.06%	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч
21.00%	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч
5.39%	МУ-ын иргэд
1.80%	Гадаадын иргэн, хуулийн этгээд
0.05%	МУ-ын хуулийн этгээд



Нийт хувьцаа ЭЗЭМШИГЧИЙН ТОО:



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Сүү ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хувьд 8 ердийн гишүүн, 4 хараат бус гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Д.ГАНБААТАР
ТУЗ-ийн дарга



Д.ЦЭРЭНЖИГМЭД
ТУЗ-ийн гишүүн



Д.ЖАМЬЯН
ТУЗ-ийн гишүүн



Д.УЯНГАЛЯНХУА
ТУЗ-ийн гишүүн



Б.ТҮВШИНТӨГС
ТУЗ-ийн гишүүн



Д.ТУНГАЛАГ
ТУЗ-ийн гишүүн



С.СҮХБОЛД
ТУЗ-ийн гишүүн



Б.ГАНТУЛГА
ТУЗ-ийн гишүүн



Б.БАТЗОРИГ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Г.БАЯР
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Н.ЦЭРЭНДОРЖ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Д.ДАВААНЫМ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод

Нэр дэвшүүлэх хороо	Аудитын хороо	Цалин урамшууллын хороо	Эрсдэлийн удирлага, комплайнсын хороо
№ Овог нэр	Албан тушаал	Ажиллах албан тушаал	
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО Б.Батзориг Д.Ганбаатар Н.Цэрэндорж	ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга Хорооны гишүүн Хорооны гишүүн	
АУДИТЫН ХОРОО Н.Цэрэндорж Д.Тунгалаг Г.Баяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга Хорооны гишүүн Хорооны гишүүн	
ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО Д.Давааням Д.Цэрэнжигмэд Г.Баяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга Хорооны гишүүн Хорооны гишүүн	
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, КОМПЛАЙНСЫН ХОРОО Н.Цэрэндорж С.Сүхболд Д.Давааням	ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга Хорооны гишүүн Хорооны гишүүн	

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



УДИРДЛАГЫН ТАНИЛЦУУЛГА



Б.Гантулга
Гүйцэтгэх захирал



Д.Бямбажав
Үйлдвэрлэл хариуцсан
дэд захирал



Д.Баасанцогт
Үйл ажиллагаа хариуцсан
дэд захирал



Ш.Даваалимбэ
Санхүү хариуцсан
дэд захирал



Б.Алтанхишиг
Эрдэнэт салбар үйлдвэр
хариуцсан дэд захирал



Б.Ганзориг
Агро ферм хариуцсан дэд
захирал



Б.Амарбаясгалан
Сүү худалдан авалтын
албаны дарга



С.Кристина
Худалдан авалт, Хангамжийн
албаны дарга



Б.Ариунболд
Захиргаа, Хуулийн албаны
дарга



Л.Байгальмаа
Хүний нөөцийн албаны
дарга



Ц.Батгэрэл
Чанар, Лабораторийн
албаны дарга



С.Оюунбилэг
Технологийн албаны
дарга



М.Батцэцэг
Дотоод аудитын албаны
дарга



Ц.Баасандорж
Тээвэр, Ложистикийн
албаны дарга



Ш.Хаш-Эрдэнэ
Маркетингийн
албаны дарга



П.Эрдэнэбаатар
Улаанбаатар хот
хариуцсан борлуулалтын
албаны дарга



С.Отгонбаатар
Техникийн албаны
дарга



М.Билэгтхүү
Борлуулалтын ахлах
менежер

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



"Сүү" ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Б.Гантулга

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амгаланг эрэн мэндчилье.

2026 оны эхний хагас жилд Сүү ХК нь үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, үйлдвэрлэл, борлуулалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, түүхий эд бэлтгэлийн тогтолцоо болон нийгмийн хариуцлагын чиглэлээр олон чухал ажлыг амжилттай хэрэгжүүллээ. Бид хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, эрүүл амьдралын хэв маягийн чиг хандлагад нийцүүлэн Naturia лактозгүй сүү, Аарцтай Suuper Shake зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг өргөжүүлэн ажиллалаа. Мөн үйлдвэрлэлийн үр ашиг, нийлүүлэлтийн тогтвортой байдлаа хадгалан хэрэглэгчдэдээ чанартай, аюулгүй бүтээгдэхүүнийг тасралтгүй хүргэхэд онцгой анхааран ажилласан билээ.

Энэхүү хүчин чармайлт, нийт хамт олны хичээл зүтгэлийн үр дүнд 2026 оны эхний хагас жилийн байдлаар компанийн борлуулалтын орлого 131.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар өссөн амжилт үзүүллээ. Түүнчлэн, цэвэр ашиг 9.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26 хувиар өссөн нь өнгөрсөн онтой харьцуулахад онцгой үр дүн байлаа.

Манай хамт олон хэрэглэгч олон нийтэд монгол түмний уламжлалт сүү цагаан идээг орчин үеийн шинэлэг техник технологи ашиглан хэрэгцээ шаардлагад нийцэхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн сацуу нийгмийн хариуцлагын чамлахааргүй ажлыг хагас жилийн хугацаанд хийж гүйцэтгээд байна.

Тухайлбал, боловсрол, хүүхэд залуучуудын хөгжилд чиглэсэн ажлуудаас дурдвал "СҮҮ365" өсвөрийн шатарчдын тэмцээнийг дөрөв дэх жилдээ зохион байгуулж, 600 гаруй хүүхэд багачуудыг хамруулан оюуны спортыг дэмжлээ. Мөн "SciCon 2026", "Milk Festival 2026", "Specialty Coffee Fest 2026" зэрэг томоохон арга хэмжээнүүдийг дэмжин ажиллаж, боловсрол, шинжлэх ухаан, салбарын хөгжлийг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр орууллаа.

Бидний хамтын хөдөлмөр, тууштай хөгжлийн үр дүнгээр Сүү ХК нь "ТОП-100 Аж Ахуйн Нэгж"-ийн жагсаалтад 49 дүгээр байрт эрэмбэлэгдэж, зургаан жил дараалан байр ахиулсан бахархам амжилтыг үзүүллээ. Энэхүү амжилт нь чадварлаг хамт олон, стандартчилагдсан үйлдвэрлэл, инновац, хэрэглэгч төвтэй хөгжлийн бодлогын бодит үр дүн юм.

Цаашид бид хэрэглэгч олны өсөн нэмэгдэх хэрэгцээг бүрэн дүүрэн хангахаас гадна уламжлалт бүтээгдэхүүнийг орчин үеийн хэрэглээнд ойртуулан шинэ бүтээгдэхүүнүүдийг ээлж дараалан зах зээлд нэвтрүүлэхээр тууштай хөдөлмөрлөх болно. Нөгөөтэйгүүр, малчин, фермерүүдийг дэмжих, хувьцаа эзэмшигчдэдээ үнэ цэн бүтээх зорилгын төлөө тууштай ажиллах болно.

Та бүхний итгэл, дэмжлэг, хамтын ажиллагаанд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

02

2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БОРЛУУЛТЫН МЭДЭЭ

- Зах зээлд нийлүүлсэн шинэ бүтээгдэхүүн
- Борлуулалтын онцлох тоон үзүүлэлтүүд



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР

ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

NATURIA ЛАКТОЗГҮЙ СҮҮ

Naturia лактозгүй сүү нь сүү уусны дараа гэдэс дүүрэх, хэвлий тавгүйрхэх зэрэг лактоз үл тэвчих шинж тэмдэгтэй хэрэглэгчдэд зориулсан шинэ бүтээгдэхүүн юм. Үйлдвэрлэлийн явцад лактозыг урьдчилан задалсан тул хүний биед илүү хялбар шингэж, энгийн сүүний адил уураг, кальци болон шаардлагатай амин дэмүүдийг бүрэн авах боломжийг олгоно.

Эрүүл, зохистой хооллолтыг эрхэмлэгчид, спортын тамирчид болон идэвхтэй амьдралын хэв маягтай хүн бүр Naturia-г өдөр тутмын хэрэглээндээ сонгох боломжтой.

ААРЦТАЙ SUUPER SHAKE

Хэрэглэгчийн өдөр тутмын хэрэглээ болсон "Suuper shake" бүтээгдэхүүн нь сүү, карамель, манго, хад жимс гэсэн төрөлтэйгөөр худалдаалагдаж байсан бол аарцтайгаар төрлөө нэмэгдүүлж зах зээлд нэвтрүүлээ. Ингэхдээ цоо шинэ савлагаатай гарснаараа онцлог байв.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР

БОРЛУУЛАЛТЫН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Нийт Сүү
↑7%



Нийт Асептик
↑16%



Нийт Зөөхий
↑15%



Нийт Тараг
↑19%



Нийт Зайрмаг
↑8%



Нийт Цөцгийн Тос
↑16%



НИЙТ БОРЛУУЛАЛТЫН
ӨСӨЛТ

↑11%

03

2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Цэвэр борлуулалт ба ашиг
- Нийтийн болон өөрийн хөрөнгийн өгөөж
- Санхүүгийн аудитлаагүй ерөнхий тойм тайлан



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ




ЦЭВЭР БОРЛУУЛАЛТ БА АШИГ

Цэвэр борлуулалт

2026 оны эхний хагас жилийн байдлаар Сүү ХК-ийн цэвэр борлуулалтын орлого 131 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулбал 15%-ийн өсөлтийг үзүүлсэн байна.


/Тэрбум төгрөг/



Цэвэр ашиг

2026 оны эхний хагас жилийн байдлаар Сүү ХК-ийн Цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26%-аар өсөж, 9.4 тэрбум төгрөгт хүрлээ.

/Тэрбум төгрөг/



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР


НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

Нийт хөрөнгийн өгөөж:



2026 оны хагас жилийн байдлаар
Сүү ХК-ийн Нийт Хөрөнгийн
Өгөөж 4.6% байна.

Өөрийн хөрөнгийн өгөөж:



2026 оны хагас жилийн байдлаар
Сүү ХК-ийн Өөрийн Хөрөнгийн
Өгөөж 12.1% байна.

2026
ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



САНХҮҮГИЙН АУДИТЛАГДААГҮЙ
ЕРӨНХИЙ ТОЙМ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2025 1-р ХАГАС	2026 1-р ХАГАС	ӨСӨЛТ
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН	(сая ₮)	(сая ₮)	(%)
Эргэлтийн хөрөнгийн дүн	56,883.42	79,334.01	39%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	110,747.26	127,787.39	15%
Нийт хөрөнгө	167,630.68	207,121.40	24%
Өр төлбөр	100,492.56	129,272.34	29%
Эздийн өмч	67,138.12	77,849.06	16%
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	167,630.68	207,121.40	24%
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	(сая ₮)	(сая ₮)	(%)
Борлуулалтын орлого (цэвэр)	114,135.11	131,119.95	15%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	81,256.12	92,309.39	14%
Нийт ашиг (алдагдал)	32,878.99	38,810.57	18%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	9,231.44	11,286.77	22%
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	7,475.09	9,441.11	26%

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт гаргасан хувьцаа:

344,000,000

Тикер	MSE:SUU
Бирж	МХБ
Ангилал	I(19),ТОП20(16) индекс
Зах зээлийн үнэ	215.6 Тэрбум
Нээлтийн ханш	615₮
Хаалтын ханш	629₮



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж 2026,06,31

04

2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- Хамтын үйл ажиллагаа
- Хүний нөөц
- Хэрэглэгчийн идэвхижүүлэлт
- Бидний ололт
- Засаглалын тайлан



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ҮХРИЙН ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛГИЙН ТЕХНИКЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Сүү ХК, Нутаг Академи, Малын удмын сангийн үндэсний төв болон Global Civic Sharing байгууллагууд хамтран “Үхрийн зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалт”-ыг гурав дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Долоо хоногийн хугацаанд эрчимжүүлсэн хэлбэрээр зохион байгуулагдсан энэхүү сургалт нь сүүний чиглэлийн үхрийн ашиг шим, үүлдэр угсааг сайжруулахын зэрэгцээ орон нутагт мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд чиглэсэн билээ. Энэ удаагийн сургалтад Сүү ХК-тай хамтран ажилладаг хоршоодын 18 гишүүн хамрагдан, үхрийн зохиомол хээлтүүлгийн онолын мэдлэг эзэмшиж, практик дадлагаар үр чадвараа бататган, техникчээр амжилттай төгслөө.

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТАКТИКИЙН ДАДЛАГА СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Гал түймэр гарах болон Химийн хорт бодис алдагдах" сэдвийн хүрээнд нөхцөл байдлыг зохиомлоор үүсгэн, бодит үйл явцад хариу арга хэмжээ авах дадлага сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Тус тактикийн дадлага сургалтын хүрээнд СХД-ийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 26-р анги болон Үндэсний аврах бригадын Химийн тусгай бүлэгтэй хамтран гал унтраах болон химийн хортой бодис алдагдсан үеийн хариу арга хэмжээ, хамтын уялдаа холбоог сайжруулан, хамтын ажиллагааг бэхжүүлээ.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ШИНЖЛЭХ УХААНД ШИМТЭГСДИЙН ЦУГЛАРАЛТ “SCICON 2026” АРГА ХЭМЖЭЭГ ДЭМЖИН АЖИЛЛАЛАА

ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Сүү ХК нь шинжлэх ухаан, боловсрол, инновацын ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх зорилготой “SciCon 2026 | What's Hidden...” арга хэмжээг дэмжин ажиллалаа. Тус арга хэмжээ нь шинжлэх ухааны мэдлэгийг олон нийтэд хүргэх, хүүхэд залуусын сониуч зан, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой Монголын хамгийн том шинжлэх ухааны цугларалтуудын нэг юм.

2026 оны арга хэмжээнд 1,000 орчим оролцогч хүрэлцэн ирж, палеонтологи, биологи, физик, хиймэл оюун ухаан, эрчим хүч, сансар судлал зэрэг өргөн хүрээний сэдвээр эрдэмтэн, судлаачдын илтгэл, хэлэлцүүлэгт оролцсон билээ.

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



HORECA FESTIVAL-2026V-Д ОРОЛЦЛОО

ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Сүү ХК нь зочлох үйлчилгээний салбарынхан болон тэдгээрийн ханган нийлүүлэгч хүнс, шингэн хүнс, хангамжийн бараа материал, үйлчилгээ болон аялал жуулчлалын салбарын байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжилтнүүд, мөн уг салбарыг сонирхогчдын цугларах "HORECA FESTIVAL-2026"-д оролцон өөрсдийн бүтээгдэхүүнийг олон нийт, ААН-үүдэд танилцууллаа.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



MILK FESTIVAL-2026-ИЙН ЕРӨХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧААР АЖИЛЛАА

ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Дэлхийн сүүний өдрийг тохиолдуулан хоёр дахь жилдээ “MILK FESTIVAL-2026” арга хэмжээ амжилттай хэрэгжлээ. Тус арга хэмжээг ХХААХҮЯ, НЗДТГ, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон үндэсний сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хамтран зохион байгуулж, Сүү ХК ерөнхий зохион байгуулагчаар ажиллаа.

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



CYY XK & SPECIALTY COFFEE FEST 2026

ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Сүү ХК нь “Specialty Coffee Fest 2026” арга хэмжээний Ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж, кофены соёл, боловсрол болон салбарын хөгжлийг дэмжлээ.

Тус арга хэмжээ нь кофе сонирхогчид, салбарын мэргэжилтнүүдийг нэг дор нэгтгэн, кофены соёл, хэрэглээний чиг хандлага, үр чадвар, инновацыг сурталчлах талбар болж өрнөсөн бөгөөд оролцогчид шинэ бүтээгдэхүүн, амт, туршлагатай танилцаж, мэдлэг солилцон салбарын хөгжилд хувь нэмэр оруулах үнэ цэнтэй хамтын ажиллагааг хэрэгжүүллээ.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



СҮҮ ХК & БИ МОНГОЛ ХҮН ХӨТӨЛБӨР

ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор гадаадад амьдарч буй монгол хүүхдүүдийг эх оронтой нь танилцуулах, үндэсний өв соёл, уламжлалыг өвлүүлэх зорилготой “Би Монгол Хүн” хөтөлбөрийн нэгэн хэсэг болж, хөтөлбөрт хамрагдсан хүүхэд багачуудыг Сүү ХК-ийн үйл ажиллагаа, үндэсний сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй танилцууллаа.

Уг хөтөлбөрт тив тивээс болон 21 аймгаас хамрагдсан бөгөөд хамгийн хол нь Бүгд Найрамдах Кени улсаас эх орноо зорьж ирсэн байна.

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



СҮҮ365: ИРЭЭДҮЙН ИХ МАСТЕР-УУДЫГ ДӨРӨВ ДЭХ ЖИЛДЭЭ ТОДРУУЛЛАА

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Сүү ХК-ийн нэрэмжит “Сүү365” өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн дөрөв дэх жилдээ амжилттай зохион байгуулагдаж, шилдгүүдээ тодрууллаа.

Оюун ухаан, тэсвэр хатуужил, үр чадварын гайхамшгийг харуулсан энэхүү тэмцээн гурван өдрийн турш үргэлжилж, 600 гаруй өсвөрийн тамирчин авхаалж самбаа, логик сэтгэлгээ, үр ухаанаараа өрсөлдөн, таван насны ангилал түс бүр таван байрыг шалгаруулж, бяцхан “Их мастер”-ууд аваргын цомоо өргөсөн юм



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР

БУРХАН БАГШИЙН ИХ ДҮЙЧИН ӨДӨР БУЯН НОМЫН ҮЙЛСЭД НЭГДЛЭЭ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15, Бурхан багшийн Их дүйчин өдөр Сүү ХК ариун цагаан сүү, сүүн бүтээгдэхүүнээ хэрэглэгчид болон монгол түмэндээ өргөн барин буян хураах сайн үйлсэд нэгдлээ.

Азийн бурхны шашинт улс орнууд хоёр мянга гаруй жилийн турш тэмдэглэн ирсэн энэхүү өдрийг НҮБ 1999 онд олон улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхээр баталсан байдаг. Монгол Улс ч мөн 2019 оноос эхлэн Бурхан багшийн Их дүйчин өдрийг бүх нийтээр тэмдэглэх баярын өдөр болгон өргөн дэлгэр тэмдэглэж ирсэн билээ.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



СҮҮН ГЭР БҮЛИЙН ДӨРВӨН АЖИЛТАНД ОРОН СУУЦНЫ УРЬДЧИЛГАА ОЛГОЛОО

ХҮНИЙ НӨӨЦ



“Сүүн гэр бүл”-ийн дөрвөн шилдэг ажилтанд сар шинийн босгон дээр орон сууцны урьдчилгаа олгон урамшуулах уламжлалаа үргэлжлүүллээ.

Энэ нь Сүү ХК-ийн тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагыг эрхэмлэсэн бодлогын нэг хэсэг бөгөөд хамт олныхоо хөдөлмөр, мэргэжлийн үр чадвар, компанийн хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлэн дэмжиж, ажилтнуудынхаа амьдралын чанар, тогтвортой ажиллах орчныг сайжруулах замаар “Сүүн гэр бүл”-ийнхээ үрт хугацааны хамтын хөгжлийг эрхэмлэн ажиллаж буй хэлбэр юм.

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



СҮҮ ХК-ИЙН 25 БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ, ФЕРМЕРҮҮД САЛБАРЫН ШАГНАЛ ХҮРТЛЭЭ

ХҮНИЙ НӨӨЦ

Сар шинийн баярын босгон дээр Сүү ХК-ийн бэлтгэн нийлүүлэгч 25 малчин, фермерийн төлөөлөл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын шагналаар шагнагдлаа.

ХХААХҮЯ-ны “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр таван бэлтгэн нийлүүлэгч, “Жуух бичиг”-ээр 20 бэлтгэн нийлүүлэгч тус тус шагнагдаж, сүү, сүүн бүтээгдэхүүний салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр, идэвх зүтгэлийг нь өндрөөр үнэлэв.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



MILANO CORTINA - 2026 14 ДЭХ УДААГИЙН ӨВЛИЙН ПАРАЛИМПЫН НААДАМД ОРОЛЦОХ ТАМИРЧДАА

ХҮНИЙ НӨӨЦ



Сүү ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд паралимпын спортын хөгжлийг дэмжиж, нийт таван тамирчинтай тогтмол хамтран ажилладаг бөгөөд өвлийн паралимпын наадмын гүйлтийн болон цанын төрөлд эх орноо төлөөлөн оролцох ОУХМ Б.Ганболд, ОУХМ Ц.Дашдорж нарт спортын өндөр амжилт хүсэн, бэлтгэл сургуулилтад нь дэмжлэг үзүүлж, урамшуулал олголоо.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР

БАЙРТАЙ СҮҮ-2 ХӨТӨЛБӨРИЙН СУПЕР ХОНЖВОРЫН БАЙРЫГ ГАРДУУЛЛАА

ХЭРЭГЛЭГЧИЙН ИДЭВХИЖҮҮЛЭЛТ



Хэрэглэгчдийнхээ итгэл, үнэнч хэрэглээг урамшуулах зорилгоор хэрэгжүүлсэн “Байртай Сүү-2” хөтөлбөрийн супер хонжворын эзэнд хоёр өрөө байрны түлхүүрийг албан ёсоор гардууллаа.

Хөтөлбөрийн супер хонжворын эзэнээр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын иргэн Ж.Эрдэнэбаяр тодорч, өдөр тутмын хэрэглээ болсон Шимт болон Милк брэндийн сүүг худалдан авч, кодоо бүртгүүлснээр шинэ байрны эзэн болсон юм.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ТАРГИЙН БАЯР ХӨТӨЛБӨРИЙГ ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ

ХЭРЭГЛЭГЧИЙН ИДЭВХИЖҮҮЛЭЛТ



Хэрэглэгчдийнхээ эрүүл мэнд, дархлааг дэмжих, сүү сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “ТАРГИЙН БАЯР-2026” урамшуулалт хөтөлбөрийг хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүллээ.



2025 онд 90 саятан сая төгрөгийн эзэн болж байсан бол энэ удаагийн хөтөлбөрийн супер хонжвор нь нэг өрөө байр байв. Хөтөлбөр 2026 оны 4-р сарын 1-нээс 7-р сарын 1-ний өдрийг хүртэл улс орон даяар зохион байгуулагдсан.

2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР

МАНЛАЙЛЛЫН БЭЛГЭ ТЭМДЭГ БОЛСОН ТУГАА МАНДУУЛЛАА

БИДНИЙ ОЛОЛТ



Энэ нь шилдэг байгууллагуудын бүтээсэн үнэ цэн, манлайлал, нийгэмд үлдээсэн бодит мөр-ийг илтгэх нэр хүндийн илэрхийлэл байлаа. Зэрэгцэн мандсан тугууд Монголын бизнесийн итгэл, хариуцлага, ирээдүйн чигийг нэгэн зэрэг тодотгов.

МҮХАҮТ-ын “ENTREPRENEUR-2025” арга хэмжээгээр “МӨНГӨН МЕРКУРИ” шагналын эзэн, Монгол Улсын шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан үндэсний ууган үйлдвэр Сүү ХК болон шилдэг ААН-үүдийн хамтаар түг мандуулах хүндэтгэлийн ёслол утга төгөлдөр боллоо.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



СҮҮ ХК БОНЗ (ESG) МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭ АВЛАА

БИДНИЙ ОЛОЛТ

Сүү ХК нь Европын Холбооны SWITCH-Asia хөтөлбөрийн санхүүжилттэй “Эдийн засгийн Ногоон Шилжилт” (SOGЕ) төслийн хүрээнд Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ/ESG) менежментийн тогтолцоондоо хөндлөнгийн үнэлгээ, аудит хийлгэн, Австралийн олон улсын баталгаажуулалтын байгууллага TQCSI (Total Quality Certification Services International)-аар баталгаажууллаа.



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



СҮҮ ХК ТОП-100 ААН-ИЙН ЖАГСААЛТАД ЗУРГААН ЖИЛ ДАРААЛАН БАЙРАА АХИУЛЛАА


БИДНИЙ ОЛОЛТ



Энэхүү амжилт нь:

- Мэргэшсэн, чадварлаг хамт олон
- Олон улсын стандартад нийцсэн үйлдвэрлэл, технологи
- Тасралтгүй шинэчлэл, инновац
- Чанарын өндөр хяналтын тогтолцоо
- Хэрэглэгч төвтэй бүтээгдэхүүн хөгжүүлэлт зэрэг хүчин зүйлсийн бодит үр дүн юм.

Монгол Улсын ууган үйлдвэр Сүү ХК нь жилийн орлого, улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, нийгмийн даатгал, ашиг болон хөрөнгийн хэмжээгээр үнэлэгддэг "ТОП-100 Аж Ахуйн Нэгж"-ийн жагсаалтад 49-р байрт эрэмбэлэгдлээ.



05

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Компанийн засаглал
- Засаглалын бодлого



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ
ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Сүү ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Сүү ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөл нь нийт 12 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааг байнгын, тогтвортой, мэргэжлийн удирдлагаар хангаж, Компанийн тухай хууль, Төрийн холбогдох эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон компанийн дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажилласан. Санхүүгийн зохицуулах хорооноос шинэчлэн баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийн дагуу ТҮЗ-ийн үйл ажиллагааны журам болоод баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР



2026

ЖИЛИЙН ЭХНИЙ ХАГАСЫН ТАЙЛАН

01 КОМПАНИ
ТАНИЛЦУУЛГА

02 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ

03 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

04 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

05 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

WWW.SUU.MN

ХӨРӨНГӨ
ОРУУЛАГЧДАД

БАРИМТ БИЧИГ

Компанийн тогтвортой хөгжлийн бодлого
Компанийн ногдол ашгийн бодлого
Компанийн залгамж халааны бодлого
Компанийн цалин урамшууллын бодлого
Компанийн дотоод аудитын заавар
Компанийн дотоод хяналтын заавар
Компанийн эрсдэлийн удирдлагын заавар
Компанийн комплаенсын хяналтын заавар
Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр
Компанийн эрх бүхий албан тушаалтны ёс зүйн дүрэм
Компанийн мэдээллийн ил тод байдлын тайлагналын журам
Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хураангуй
Компанийн хөрөнгө оруулалт, худалдан авалтын
ажиллах журам, сонирхлын зөрчлийн зохицуулах журам
ТУЗ-ийн оролцооны талын бодлого
ТУЗ-ийн нэр дэвшүүлэх журам
ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам
ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
Аудитын дүрэм

Та энэхүү заавраар
холбогдох мэдээллийг
авах боломжтой



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Монгол улс, Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37,
СҮҮ ХК-ийн байр